

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Албан шаардлага.....	9
3.2 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 85

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд Төлөөлөгчөөр сонгогдсон гишүүдийн тоонд үндэслэн улс төрийн намуудад нийт 42,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, хоолны хөнгөлөлтийг бусад байгууллагуудын жишиг нормоор тогтоогоогүй, нийтийн тээвэр зорчдоггүй нутаг дэвсгэрт үндэслэлгүй унааны хөнгөлөлт тооцон нийт 2,324.5 мянган төгрөг олгосон, хүүхдийн баярын бэлэгт 413.0 мянган төгрөг зарцуулсан зэрэг нийт 44,738.1 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон 5,292.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-т "Энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах", 34 дүгээр зүйлийн 34.6-д "Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно", 34.6.3-д Төрийн байгууллага болон

452050184

нутгийн өөрөө удирдах байгууллага" гэж заасантай тус тус нийцээгүй бөгөөд бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нийт 21 төлөөлөгчтэйгөөр үйл ажиллагаа явуулсан бөгөөд газар зохион байгуулалтын төлөвлөгөө гаргах, төсөвт тодотгол хийх, дараа оны төсөв батлах, сумын засаг даргын мөрийн хөтөлбөрийн тухайн жилд хийх ажил зэргийг хэлэлцэн нийт 7 удаа хуралдан холбогдох шийдвэрийг гаргаж, хурлын зардал гаргасныг бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2025 онд 7 зорилт 42 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,654,117.90	5,836,153.84
АВЛАГА	550,000.00	-
Ажиллагчидтай холбогдсон авлага	550,000.00	
Хангамжийн материал	6,104,117.90	5,836,153.84
Бичиг хэргийн материал	526,900.00	770,900.00
Аж ахуйн материал	2,750,955.00	2,750,955.00
Түлш, шатах тослох материал	1,426,772.90	914,808.84
Бусад хангамжийн материал	1,399,490.00	1,399,490.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,505,741.19	10,389,241.52
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,505,741.19	10,389,241.52
Биет хөрөнгө	13,505,741.19	10,389,241.52
Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,289,200.00	18,556,200.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,793,635.49)	(8,857,072.05)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,479,800.00	2,479,800.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,469,623.32)	(1,789,686.43)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,159,859.09	16,225,395.36
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,159,859.09	16,225,395.36
Засгийн газрын хувь оролцоо	20,159,859.09	16,225,395.36
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,736,944.00	3,736,944.00
Өмч: - төрийн	3,736,944.00	3,736,944.00
Хуримтлагдсан үр дүн	16,422,915.09	12,488,451.36
Өмнөх үеийн үр дүн	16,422,915.09	15,872,915.09
Тайлант үеийн үр дүн		(3,384,463.73)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,159,859.09	16,225,395.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	283,996,600.00	282,826,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	283,996,600.00	282,826,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,600,000.00	13,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,600,000.00	13,600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	270,396,600.00	269,226,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	270,396,600.00	269,226,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	262,632,181.30	286,210,863.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,632,181.30	286,210,863.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,081,380.05	199,687,331.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,975,149.61	155,841,709.66
210101	Үндсэн цалин	77,035,379.87	81,053,867.58
210102	Нэмэгдэл	70,322,731.25	56,568,099.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,969,538.49	2,324,500.00
210104	Урамшуулал	7,647,500.00	15,895,242.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,570,049.14	18,601,708.49
210201	Тэтгэврийн даатгал	13,120,032.63	11,791,100.92
210202	Тэтгэмжийн даатгал	1,683,445.95	1,634,500.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	892,583.80	1,021,444.96
210204	Ажилгүйдлийн даатгал	776,381.25	885,662.61
210205	Эрүүл мэндийн даатгал	3,097,605.51	3,269,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,138,418.93	9,198,864.06
210401	Бичиг хэрэг	6,558,831.83	2,397,650.00
210402	Тээвэр, шатахуун	5,048,227.10	5,323,764.06
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	674,460.00	596,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	856,900.00	881,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	3,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,000,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	2,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,100,000.00	364,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,100,000.00	364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,236,600.00	5,131,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,084,100.00	3,038,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	742,500.00	742,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	410,000.00	1,350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,861,162.37	6,850,863.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,436,600.00	1,187,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	2,279,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,924,562.37	3,383,463.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,550,801.25	68,146,481.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,500,000.00	42,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,500,000.00	42,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		12,870,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,110,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,424,000.00	5,507,050.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,050,801.25	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,050,801.25	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	26,146,481.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,146,481.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>11,571,110.53</u>	<u>(3,384,463.79)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>11,571,110.53</u>	<u>(3,384,463.79)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>283,996,600.00</u>	<u>282,826,400.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	283,996,600.00	282,826,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,600,000.00	13,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,600,000.00	13,600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	270,396,600.00	269,226,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	270,396,600.00	269,226,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>271,609,400.00</u>	<u>282,559,400.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,609,400.00	282,559,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	209,424,598.75	198,339,318.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,975,149.61	155,841,709.66
210101	Үндсэн цалин	77,035,379.87	81,053,867.58
210102	Нэмэгдэл	70,322,731.25	56,568,099.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,969,538.49	2,324,500.00
210104	Урамшуулал	7,647,500.00	15,895,242.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,508,049.14	18,601,708.49
210201	Тэтгэврийн даатгал	13,058,032.63	11,791,100.92
210202	Тэтгэмжийн даатгал	1,683,445.95	1,634,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	892,583.80	1,021,444.96
210204	Ажилгүйдлийн даатгал	776,381.25	885,662.61
210205	Эрүүл мэндийн даатгал	3,097,605.51	3,269,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,986,000.00	8,634,900.00
210401	Бичиг хэрэг	1,979,640.00	2,345,650.00
210402	Тээвэр, шатахуун	6,475,000.00	4,811,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	674,460.00	596,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	856,900.00	881,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	2,700,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	2,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	364,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,392,600.00	8,982,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,350,100.00	6,890,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	742,500.00	742,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	1,350,000.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,362,800.00	3,214,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,862,800.00	935,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	2,279,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,184,801.25	84,220,081.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,500,000.00	42,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,500,000.00	42,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,634,000.00	16,073,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		12,870,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,110,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,524,000.00	3,203,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,050,801.25	26,146,481.85

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,050,801.25	26,146,481.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,387,200.00</u>	<u>267,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,387,200.00	267,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,387,200.00	267,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,387,200.00	267,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,387,200.00	267,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(12,387,200.00)</u>	<u>(267,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,736,944.00	4,070,767.61	7,807,711.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,736,944.00	4,070,767.61	7,807,711.61
Тайлант үеийн үр дүн	-	(1,865,267.82)	(1,865,267.82)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,736,944.00	16,422,915.09	20,159,859.09
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,736,944.00	2,205,499.79	5,942,443.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(550,000.00)	(550,000.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,736,944.00	15,872,915.09	19,609,859.09
Тайлант үеийн үр дүн	-	(3,384,463.73)	(3,384,463.73)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,736,944.00	12,488,451.36	16,225,395.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	309,169,700.00	269,226,400.00	39,943,300.00
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	309,169,700.00	269,226,400.00	39,943,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	309,169,700.00	269,226,400.00	39,943,300.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	309,169,700.00	245,079,918.15	64,089,781.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	309,169,700.00	245,079,918.15	64,089,781.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249,299,700.00	187,006,318.15	62,293,381.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,321,000.00	155,841,709.66	46,479,290.34
210101	Үндсэн цалин	86,345,800.00	81,053,867.58	5,291,932.42
210102	Нэмэгдэл	99,800,600.00	56,568,099.73	43,232,500.27

210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,772,000.00	2,324,500.00	447,500.00
210104	Урамшуулал	13,402,600.00	15,895,242.35	-2,492,642.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,290,300.00	18,601,708.49	6,688,591.51
210201	Тэтгэврийн даатгал	17,197,300.00	11,791,100.92	5,406,199.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,023,200.00	1,634,500.00	388,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,011,700.00	1,021,444.96	-9,744.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,011,700.00	885,662.61	126,037.39
210205	Эрүүл мэндийн даатгал	4,046,400.00	3,269,000.00	777,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,358,400.00	4,134,900.00	2,223,500.00
210401	Бичиг хэрэг	2,071,800.00	1,276,650.00	795,150.00
210402	Тээвэр, шатахуун	2,375,000.00	1,380,800.00	994,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	669,600.00	596,250.00	73,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,242,000.00	881,200.00	360,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	-	750,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	750,000.00		750,000.00
2107	Томиллолт, зочны зардал	1,500,000.00	364,000.00	1,136,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	364,000.00	1,136,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,830,000.00	7,213,500.00	616,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,680,000.00	5,121,000.00	-441,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,350,000.00	742,500.00	607,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,000.00	1,350,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,250,000.00	1,214,500.00	4,035,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,000.00	935,500.00	2,214,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,100,000.00	279,000.00	1,821,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,870,000.00	58,073,600.00	1,796,400.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	42,000,000.00	42,000,000.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	42,000,000.00	42,000,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,870,000.00	16,073,600.00	1,796,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,870,000.00	12,870,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	1,803,600.00	3,196,400.00

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөө/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,600,000.00	11,600,000.00	2,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,600,000.00	11,600,000.00	2,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,600,000.00	11,600,000.00	2,000,000.00
210401	Бичиг хэрэг		1,069,000.00	

210402	Түлш шатахуун		3,431,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,650,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамгуулал		1,450,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,600,000.00	13,600,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,600,000.00	13,600,000.00	-
131103	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,600,000.00	13,600,000.00	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44,738.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

3.1 Албан шаардлага

1. Тайлант онд байгууллагын төсвөөс намуудад суудлын мөнгө 42,000,000.00 төгрөг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 10.1.5-д "Энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах", 34 дүгээр зүйлийн 34.6-д "Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно", 34.6.3-д "Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тайлант онд хүндэтгэл үзүүлэх тушаал гарган ажилчдын хүүхдүүдэд төсвийн хөрөнгөөр 413,600.00 төгрөгийн бэлэг худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, **хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах**", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг **зориулалтын дагуу зарцуулах**", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг **хориглоно**", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр **бэлэг** дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хоолны хөнгөлөлтийн мөнгийг дотоод журамд тусгасан боловч бусад салбар нэгж байгууллагуудын хоолны хөнгөлөлтийн дүнгээс өндөр, үндэслэлгүйгээр унааны мөнгийг нэмэлтээр тооцон 2,324.5 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, **хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах**", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "**батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн**

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэхь заалтыг баримталж, хоол унааны хөнгөлөлтийн мөнгөн дүнг үндэслэлтэй тогтоож ажиллах.

Дээрх тайлангийн 5.2 дахь хэсэгт дурдсан албан шаардлага, 5.3 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд байгууллагын төсвөөс намуудад суудлын олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	42,000.0	-	-	1	42,000.0	-	-	-	-	
Тайлант онд хүндэтгэл үзүүлэх тушаал гарган ажилчдын хүүхдүүдэд төсвийн хөрөнгөөр бэлэг худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	413.6	-	-	1	413.6	-	-	-	-	
Хоолны хөнгөлөлтийн мөнгийг дотоод журамд тусгасан боловч бусад салбар нэгж байгууллагуудын хоолны хөнгөлөлтийн дүнгээс өндөр, үндэслэлгүйгээр унааны мөнгийг нэмэлтээр тооцон олгосон	1	2,324.5	-	-	-	-	1	2,324.5	-	-	
Дүн	3	44,738.1	-	-	2	42,413.6	1	2,324.5	-	-	-

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.